



МОНГОЛ УЛС
ХЭНТИЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2022 оны 03 сарын 02 өдөр

Дугаар А/113

Хэрлэн сум

Иргэн-цэргийн харилцааг
бэхжүүлэх ажил зохион байгуулахад
хөрөнгө зарцуулах тухай.

Монгол Улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, 60 дугаар зүйлийн 60.1.1, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.13 дахь заалт, Батлан хамгаалах тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.1.10 дахь заалт, Сангийн сайдын 2021 оны 61 дүгээр тушаалын 2.1.5 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Иргэн-цэргийн харилцааг бэхжүүлэх, хугацаат цэргийн алба хаагч болон анги байгууллагад аймаг орон нутгийн үйл ажиллагааг сурталчлах, хугацаат цэргийн албан хаагчдын талаар нэвтрүүлэг бэлтгэж, орон нутгийн хэвлэл мэдээллийн хэрэгслээр сурталчлах ажиллагааг 2022 оны 3 дугаар сарын 04-ний өдрөөс 2022 оны 3 дугаар сарын 07-ны өдрүүдэд Зэвсэгт хүчний 327, Хилийн цэргийн 0198 дугаар ангиудад зохион байгуулахад 2.308.580 (хоёр сая гурван зуун найман мянга, таван зуун наян) төгрөгийн хөрөнгө зарцуулсугай.

2. Иргэн-цэргийн харилцааг бэхжүүлэх ажлыг зохион байгуулахад шаардагдах төсвийг хавсралтаар баталсугай.

3. Дээрх үйл ажиллагаанд шаардагдах хөрөнгийг Засаг даргын нөөц сангийн нэг удаагийн шинжтэй арга хэмжээний зардлаас зарцуулахыг Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга (С.Нямдаваа)-д зөвшөөрсүгэй.

ЗАСАГ ДАРГА



Ц.ЧОГСОМЖАВ

231010321

Аймгийн Засаг даргын 2022 оны
03 дугаар сарын 02 өдрийн
А/116 захирамжийн хавсралт

ИРГЭН-ЦЭРГИЙН ХАРИЛЦААГ БЭХЖҮҮЛЭХ
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТӨСӨВ

| № | Зардлын нэр | Тоо | Нэг бүрийн үнэ | Нийт үнэ | Хянасан |
|---|---|------|----------------|-----------|---------|
| 1 | Ангийн алдарын буланд Хэнтий аймгийн талаар мэдээллийн самбар байрлуулах /Зэвсэгт хүчний 327, Хилийн 0198, 0306-р анги/ | 3 | 200000 | 600000 | |
| 2 | Хугацаат цэргийн албан хаагчдын талаарх нэвтрүүлэг | 1 | 500000 | 500000 | |
| 3 | Бензин Аи-92 | 252л | 2415 | 608500 | |
| 4 | Томилолт | 3 | 50000 | 600000 | |
| | Нийт | | | 2.308.580 | |